

**БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

2026 оны 06 дугаар сарын 06-ны өдөр



С.АМАРСАЙХАН

ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэний эрх, үүргийг тодорхойлох, Монгол Улсад орох, гарах, дамжин өнгөрөх, оршин суух харилцааг зохицуулах, түүнчлэн үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журмыг хамгаалах зорилгоор олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийг хуулиар хязгаарлах, түүнчлэн Монгол Улсын төртэй харилцах харилцааны үндсийг тогтоосон суурь хууль юм.

Уг хуулийг шинэчлэн найруулах нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, төрийн бодлогын баримт бичигт туссан зорилттой нийцүүлэх, түүнчлэн хуулийн хэрэгжилтийн явцад илэрсэн зохицуулалтын тодорхой бус байдал, уялдаа, хэрэгжилтийн хүндрэл зэрэг нөхцөл байдлыг харгалзан эрх зүйн орчныг боловсронгуй болгох дараахь үндэслэл, шаардлагад тулгуурлаж байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван наймдугаар зүйлд “Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг тодорхойлохдоо Монгол Улсын хууль, уул иргэнийг харьяалсан улстай байгуулсан олон улсын гэрээ, харилцан адил байх зарчмыг баримтлах”-аар, “Монгол Улс нутаг дэвсгэртээ байгаа харьяалалгүй хүний эрх, үүргийг өөрийн хуулиар тогтоох, Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлал тогтооно” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалах, бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан аялал жуулчлалыг хөгжүүлэх” зорилтыг дэвшүүлсэн.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1.11-д “визийн зөрчилтэй гадаад иргэдийн тоог бууруулах, гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох” гэж, мөн хөтөлбөрийн 4.1.1.14-т “Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, хуулиас давсан зохицуулалт бүхий дүрэм, журмуудад дүн шинжилгээ хийж, цэгцлэх арга хэмжээ авна” гэж тус тус заасан.

1.2.Практик хэрэгцээ, шаардлага

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах дараах практик хэрэгцээ, шаардлага байна. Үүнд:

1.Журмаар зохицуулж буй суурь харилцааг хуулийн түвшинд зохицуулах талаар

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд хуулиар зохицуулах ёстой суурь харилцааг журам, дүрэм, заавраар зохицуулахаар холбогдох этгээдэд хэм хэмжээний акт батлах эрх олгосон олон зохицуулалт тусгагдсан бөгөөд виз олгох, оршин суух, албадан гаргах, гадаадын иргэний үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, хяналт тавих, гарахыг түдгэлзүүлэх харилцааг Засгийн газар, сайд, холбогдох байгууллагын удирдлагын баталсан журмаар зохицуулж байна.

Ийнхүү гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй холбогдох суурь шинжтэй харилцааг хуулиар бус, хэм хэмжээний актаар зохицуулж байгаа нь хууль тогтоомжийн тодорхой, ойлгомжтой, нэг мөр хэрэгжих зарчимд нийцэхгүйгээс гадна хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахтай холбоотой зохицуулалтыг заавал хуулиар тогтоох Үндсэн хуулийн шаардлагад бүрэн нийцэхгүй байна.

2.Монгол Улсын визийн зохицуулалтын талаар

Монгол Улсын визийн ангилал нь олон төрөл, давхардсан, практикт хэрэглэгдэхгүй ангилал бүхий байдлаар тогтоогдсон нь иргэн, уригч этгээдэд ойлгомжгүй, хэрэгжилтэд хүндрэл үүсгэж байна. Иймд визийн ангиллыг олон улсын жишигт нийцүүлэн оновчтой болгох шаардлага үүссэн.

Энэ хүрээнд одоогийн 64 ангиллыг 42 ангилал болгон цөөрүүлж, давхардсан болон ач холбогдол багатай ангиллыг нэгтгэн дипломат, албан, хөрөнгө оруулах, хөдөлмөр эрхлэх, суралцах, гэр бүлийн шалтгаан, цагаачлах, Монгол Улсын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан гадаадын иргэн болон түр ирэгч зэрэг олон улсын нэршилд нийцүүлэн ангилах, түүнчлэн Монгол Улсын иргэний харьяатаас гарсан болон Монгол Улсын иргэнээс төрсөн гадаадын иргэнд олгож буй визийн нөхцөлийг сайжруулж, одоо 30 хоног байх хугацаатай, олон удаагийн визийг 1 жилээр олгож байгааг Монгол Улсад 90 хоног байх хугацаатай, олон удаагийн визийг 5 жилийн хугацаатай олгож, визийн хураамжаас чөлөөлөх замаар эх оронтойгоо харилцах нөхцөлийг дэмжих нь зүйтэй байна.

Мөн Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцийн дагуу олон улсын нисэх багийн бүрэлдэхүүнийг визийн шаардлагаас чөлөөлөх зохицуулалтыг

хуульд тусгаж, 72 хүртэл цагийн хугацаатай нэвтрэхэд виз шаардахгүй байх, мөн виз хүсэх, шийдвэрлэх үйл явц бүрэн цахимжсан нөхцөлд визийн төвөөр заавал дамжуулан биечлэн бичиг баримт хүлээн авах шаардлага буурсан, хил орчмын жуулчинд олгох виз нь 30 хүртэлх хоногийн хугацаатай байх, жуулчлах нутаг дэвсгэрийн хязгаар заагаагүй, тус ангиллын визийг авснаар хил орчмын нутаг дэвсгэрийн дэглэм зөрчигдөх, визийн хугацааг хэтрүүлэх зэрэг эрсдэл бий болж байгаа тул холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

3. Гадаадын иргэний бүртгэлийн талаар

Сүүлийн жилүүдэд гадаадын иргэдийн шилжилт хөдөлгөөн нэмэгдэж байгаа боловч бүртгэл, хяналтын тогтолцоо нь техник, технологид бүрэн суурилагүй, мэдээлэл урьдчилан авах, боловсруулах боломж хязгаарлагдмал байна. Үүнээс шалтгаалан хил дээрх ачаалал нэмэгдэх, зорчигчийн урсгалыг оновчтой зохион байгуулахад хүндрэл үүсч байна.

Мөн гадаадын иргэний бүртгэл, хаягийн мэдээлэл, оршин суух зөвшөөрлийн бүртгэл хоорондын уялдаа сул, байгууллагуудын мэдээллийн сан харилцан уялдаагүй байгаагаас бүртгэл, хяналтын нэгдмэл байдал алдагдаж, хяналтын үр нөлөө буурч байна. Тухайлбал, Монгол Улсын хилээр нэвтэрч /орсон, гарсан/ байгаа гадаадын иргэдийн мэдээллийг бодит цагийн горимоор хяналт тавих эрх бүхий байгууллага авч чадахгүй байна.

Түүнчлэн гадаадын иргэний хаягийн бүртгэлийг сум, хорооны тодорхойлолтод тулгуурлан хийж буй нь иргэн, хуулийн этгээдэд хүндрэл, чирэгдэл үүсгэхээс гадна бичиг баримтын давхардал, хүнд суртал, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг бий болгож байна.

Дээрх нөхцөл байдалтай холбогдуулан гадаадын иргэний бүртгэл, хяналтын тогтолцоог техник, технологид суурилсан нэгдсэн системд шилжүүлэх, мэдээллийг урьдчилан авах, боловсруулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх, бүртгэл, хаяг, оршин суух зөвшөөрлийн мэдээллийн уялдааг хангах, мөн бичиг баримтын давхардал, хүндрэл, чирэгдлийг бууруулах чиглэлээр холбогдох зохицуулалтыг хуулийн түвшинд боловсронгуй болгох шаардлага үүсч байна.

4. Монгол Улсад гадаадын иргэн оршин суух зохицуулалтын талаар

Олон улсын жишигт оршин суух зөвшөөрлийг “албан” ба “хувийн” гэж заавал ангилдаггүй боловч, төрийн болон олон улсын албан үүрэгт суурилсан оршин суух хэлбэрийг хувийн зорилгоор оршин суухаас тодорхой зааглаж, тоон хязгаарлалт хийдэггүй байна.

Иймээс оршин суух зөвшөөрлийг визийн ангилалтай уялдуулан түр оршин суух, байнга оршин суух хэлбэрээр тодорхой ангилж, албан зорилго, хөрөнгө оруулах, хөдөлмөр эрхлэх, суралцах, гэр бүлийн, цагаачлах, Монгол Улсын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан гадаадын иргэн зэрэг зорилго бүрт тохирсон нөхцөл, хугацаа, сунгалтын шалгуурыг нарийвчлан тогтоох шаардлагатай байна. Үүнд:

Монгол Улсын нутаг дэвсгэрт аль ч улсын иргэний харьяалалгүй болох нь тогтоогдсон хүнд “SP” (stateless person) ангиллын түр оршин суух зөвшөөрлийг олгож, Монгол Улсын нутаг дэвсгэрт буй харьяалалгүй хүний суурь эрхийг (сурч боловсрох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах, хөдөлмөр эрхлэх гэх мэт)

баталгаажуулах, хүний эрхийг дээдэлдэг ардчилсан улсын хувьд олон улсын хамтын ажиллагаанд өөрийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, тус улсад амьдарч буй баримт бичгийн зөрчилтэй, эсхүл харьяалал нь тодорхойгүй хүмүүсийг бүртгэлжүүлэх;

Түүнчлэн Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд хэрэгжих бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийн шугамаар хөдөлмөр эрхлэх гадаадын иргэнд оршин суух зөвшөөрөл олгохдоо хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний эрх олгосон байгууллагаас олгодог хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн бичгийг давхар шаардахгүйгээр уригч хуулийн этгээдэд үүсдэг нэмэлт шат дамжлага, хугацаа шаардах асуудлыг арилгах, хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авахаас үүдэн виз, бүртгэлийн зөрчил гарах эрсдэлийг бууруулах, улмаар төрийн үйлчилгээний давхардлыг багасган, үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх;

Дэлхийн боловсролын салбарын хөгжлийн чиг хандлага нь боловсролын чанарын баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлэх, сургалт, судалгааны үр дүнг дээшлүүлэх, хууль бус суралцагчийн тоог багасгах зорилгоор зөвхөн магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуульд гадаадын оюутан, мэргэжилтэн бэлтгэх, сургах зөвшөөрөл олгох, улмаар их, дээд сургуульд суралцагч гадаадын иргэний суралцах зорилгыг алдагдуулахгүйгээр ажлын бүтэн бус цагаар ажиллуулах байдлаар хөдөлмөрийн зах зээлд зохистой оролцох эрх зүйн суурийг бүрдүүлж, олон улсын жишигт нийцүүлэх шаардлагатай байна.

5.Гадаадын иргэдэд тавих хяналт шалгалтын талаар

Монгол Улсад нэвтэрсэн гадаадын иргэдийг улсын хилээр нэвтрэхээс 72 цагийн өмнө урьдчилсан цахим бүртгэл, хил хамгаалах байгууллагын хил нэвтрэлтийн мэдээллийн сан, гадаадын иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэснээс эхлэн цахим хэлбэрээр боловсруулалт хийх, мэдээллийг цуглуулж, боловсруулах замаар хяналт шалгалтыг зохион байгуулах, гадаадын иргэнд цахимаар болон биечлэн хяналт тавих эрх зүйн зохицуулалт шаардлагатай байна.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар албадан гаргах ажиллагаанд саад учруулж эсхүл гэмт хэрэг зөрчил гаргаж болзошгүй, Монгол Улсаас сайн дураар гарах сануулгыг биелүүлээгүй үндэслэлээр саатуулах нь прокурорын хяналтад хамаардаггүйгээс шүүхээр гадаадын иргэнийг саатуулахад цаг хугацаа ихээхэн шаардаж байна.

Иймд үндэсний аюулгүй байдлын эсрэг үйл ажиллагаа явуулж болзошгүй этгээд гэж үзэн гүйцэтгэх ажиллагааны шугамаар олж илрүүлсэн гадаадын иргэнийг албадан гаргуулахаар урьдчилан мэдэгдэлгүйгээр ирүүлдэг, мөн хорихоос хугацааны өмнө магадлангаар суллагдсан, баримт бичиггүй, хил зөрчигч зэрэг гадаадын иргэнийг ажлын цаг дууссаны дараа шууд суллан гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгдөг зэрэг гэнэтийн зарим нөхцөл байдлаас шалтгаалан гадаадын иргэнийг саатуулах шаардлага үүсдэг тул 72 цаг хүртэл хугацаагаар саатуулах талаарх зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.

Олон улсын жишгийг авч үзвэл, ХБНГУ, Шинэ Зеланд, Сингапур зэрэг улсын гадаадын иргэний эрх зүйн байдлыг зохицуулж буй суурь хууль тогтоомжид зөрчил гаргасан гадаадын иргэнд сануулах, торгох, баривчлах, хууль бусаар олсон орлогыг хураах, албадан гаргах зэрэг хэд хэдэн төрлийн үндсэн арга хэмжээг авах тухай

нийтлэг арга хэмжээг заасан байна.¹

Мөн БНХАУ-ын 2012 онд баталсан Хилээр орж гарах тухай хуульд албадан гаргах нь захиргааны шийтгэлийн нэг төрөл бөгөөд зөвхөн гадаадын иргэнд хамааран хэрэгждэг байна. Албадан гаргах тухай мэдэгдлийг Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамнаас өгдөг бөгөөд ихэвчлэн 1-5 жилийн хугацаатай байдаг байна. Хугацаа хэтрүүлэх, улсын аюулгүй байдалд халдсан, ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан болон бусад хууль тогтоомжийг зөрчсөн бол гадаадын иргэнийг албадан гаргадаг бөгөөд заргалдах эрхгүйгээр харьяалах улсад нь хуяглан хүргэж, хууль зүйн тусламж үзүүлдэггүй байна. Дээрх зөрчлийг гаргасан гадаадын иргэний зөрчлийг шийдвэрлэх зорилгоор саатуулан шалгадаг бөгөөд эхний удаад 30 хоног, шаардлагатай бол 60 хоног саатуулдаг, харин өвчтэй, жирэмсэн эсхүл бага насны хүүхэдтэй, 18 наснаас доош, 70 наснаас дээш настай хүн, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон бол саатуулахгүйгээр шалгадаг байна.² Олон улсад тухайн улс өөрийн нутаг дэвсгэрээс гадаадын иргэнийг албадан гаргах шийдвэрийг хүчингүй болгох, чөлөөлөх үндэслэл байдаггүй байна.

Иймээс Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.9 дэх хэсэгт заасан гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргахаас чөлөөлдөг болон цуцалдаг зохицуулалт нь хүнд суртал, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шийдвэр гаргалтад субъектив байдлаар хөндлөнгөөс нөлөөлдөг тул хүчингүй болгох шаардлагатай байна.

Харин зарим улс орон гадаадын иргэнийг сайн дурын үндсэн дээр эх орондоо буцах боломжийг дэмжих аян, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Солонгос Улсад сайн дураар нутаг буцах аян нь тус улсад виз болон оршин суух зөвшөөрлийн хугацааг хэтрүүлэн хууль бусаар оршин суугаа гадаадын иргэдийг сайн дураар нутаг буцах нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ тус улсад дахин зорчиход виз болон хилийн хоригоос чөлөөлдгөөрөө онцлогтой юм. Статистик мэдээллийг үндэслэн “Сайн дураар нутаг буцах аян”-г тодорхой хугацаатай зохион байгуулдаг бөгөөд дуусмагц хяналт шалгалтыг идэвхтэй явуулж, хууль бусаар оршин сууж буй иргэдийг албадан гаргах, хэтрүүлсэн өдөр хоногийг харгалзан торгууль ногдуулах, хилээр дахин оруулахгүй байх хугацааг 5 хүртэлх жилээр тогтоож, тухайн иргэнийг ажиллуулж байсан аж ахуйн нэгжид өндөр торгууль ногдуулах зэрэг хатуу арга хэмжээг авдаг байна.

Мөн зарим оронд ийнхүү хэрэгжүүлдэг сайн туршлагыг нутагшуулж “Сайн дураар нутаг буцах аян”-г зарлах эрх зүйн зохицуулалтыг бий болгох хэрэгцээ, шаардлага гарч байна.

6. Бусад асуудлаар

1951 оны Дүрвэгсдийн эрх зүйн байдлын конвенцид Монгол Улс нь нэгдэн ороогүй тул дүрвэгсдийн баримт бичигтэй хүнд энэ хууль үйлчлэхгүй байх, даяаршлын үйл явцад нийцүүлэн гадаадын иргэдийн монгол хэл, соёл, зан заншлыг сурталчлан таниулах, нийгэм-эдийн засгийн идэвхтэй оролцоог хангах, олон нийтийн эерэг хандлагыг бүрдүүлэх, мэдээ, мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, нийгэмд дасан зохицох олон талт нийгмийн судалгаа хийх эрх зүйн үндсийг

¹ Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын зарим зохицуулалт, харьцуулсан судалгаа. Хууль зүйн үндэсний хүрээлэн. УБ., 2015 он. 96 дахь тал.

² Монгол Улсын хилээр орох, гарах ба цагаачлалын менежментийн семинар, 2023, Бээжин, БНХАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалахын их сургууль

тусгаснаар хүний эрх, үндэсний аюулгүй байдал, эдийн засаг, нийгмийн ашиг сонирхлыг тэнцвэртэй хангах, гадаадын иргэдийн шилжилт хөдөлгөөний чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгаа, шинжилгээ хийх эрх зүйн үндсийг бүрдүүлэх нь зүйтэй юм.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зорилго нь гадаадын иргэн, харьяалалгүй хүний эрх зүйн байдлыг тогтоож, тэдгээрийн Монгол Улсын виз, оршин суух зөвшөөрөл авах, бүртгүүлэх, уригчийн эрх, үүрэг, хяналт шалгалт, хариуцлагатай холбогдсон харилцааг Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийн суурь зарчимд нийцүүлэн зохицуулахад оршино.

Түүнчлэн гадаадын иргэний талаарх төрийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг хангах, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, төрийн байгууллага, албан тушаалтны чиг үүрэг, бүрэн эрхийг тодорхой болгох замаар хүний эрхийг хангах, үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засгийн ашиг сонирхлыг тэнцвэртэй хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэнэ.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 14 бүлэгтэй байх бөгөөд дараах үндсэн харилцааг зохицуулна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж, хуулийн хамрах хүрээ, нийтлэг зарчим, дипломат төлөөлөгч, консулын газрын ажилтны дипломат эрх ямба, дархан эрх, мөн хуулийн нэр томъёоны тодорхойлолт;

Хоёрдугаар бүлэгт гадаадын иргэний эрх, үүргийн үндсэн зарчим, онцлог, уригчийн эрх, үүрэг, гадаадын иргэн, хуулийн этгээдэд хориглох зүйл;

Гуравдугаар бүлэгт Монгол Улсын виз, визийн зориулалт, төрөл, хүчинтэй хугацаа, Монгол Улсад байх хугацааг визээр тодорхойлох, визийн ангилал, виз олгох байгууллага, виз, оршин суух зөвшөөрөл олгох байгууллагын бүрэн эрх, Монгол Улсын визийн байх хугацааг сунгах;

Дөрөвдүгээр бүлэгт виз олгох, сунгах асуудлыг хянан шийдвэрлэх ажиллагаа, виз олгох, сунгахаас татгалзах, хүчингүй болгох;

Тавдугаар бүлэгт Монгол Улсад орох, орохыг үл зөвшөөрөх, мөн Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх зохицуулалт;

Зургаадугаар бүлэгт гадаадын иргэнийг бүртгэх, бүртгэхээс чөлөөлөх, гэр бүлийн байдал болон хаягийн бүртгэл;

Долоодугаар бүлэгт Монгол Улсад түр болон байнга оршин суух, түр ирэгч гадаадын иргэнд оршин суух зөвшөөрөл олгох, улсын онц чухал объектод гадаадын иргэн ажиллуулах зөвшөөрөл;

Наймдугаар бүлэгт оршин суух зөвшөөрлийг олгох, сунгах асуудлыг хянан шийдвэрлэх ажиллагаа, бүрдүүлэх баримт бичиг, оршин суух зөвшөөрөл олгох,

сунгахаас татгалзах, цуцлах, хүчингүй олгох, оршин суух үнэмлэх болон харьяалалгүй хүнд зорчих үнэмлэх олгох;

Есдүгээр бүлэгт Монгол Улсаас гарах, гарахыг сануулах, гарахыг түдгэлзүүлэх, гадаадын иргэнийг саатуулах, албадан гаргах, албадан гаргах гадаадын иргэний Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацаа, гадаадын иргэнийг шилжүүлэх улс, хуяглан хүргэх, сайн дураар нутаг буцах аян;

Аравдугаар бүлэгт гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан;

Арван нэгдүгээр бүлэгт олон улсын болон гадаад улсад төвтэй төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт зөвшөөрөл олгох, сунгах, сунгахаас татгалзах, хүчингүй болгох, салбар, төлөөлөгчийн газрын санхүүжилт, үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээлэлд орсон өөрчлөлтийг бүртгэх;

Арван хоёрдугаар бүлэгт төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрх;

Арван гуравдугаар бүлэгт төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх, албан хаагч, түүний бүрэн эрх, баталгаа;

Арван дөрөвдүгээр бүлэгт хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага;

Арван тавдугаар бүлэгт хугацаа тодорхойлох, тоолох журам, хууль хүчин төгөлдөр болох хугацаа.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэмд, эдийн засаг, хууль зүйн дараах эерэг үр дагавар бий болно. Үүнд:

1.Визийн ангиллыг цөөлж, илүү ойлгомжтой болгох, хэрэгжих боломжгүй болон давхардсан зохицуулалтыг хасах замаар хууль хэрэглээний тодорхой, нэг мөр хэрэгжих нөхцөл бүрдэнэ. Мөн аялал жуулчлалыг дэмжих, Монгол Улсын иргэнээс төрсөн гадаадын иргэний тус улсад зочлох нөхцөл хялбаршина;

2.Гадаадын иргэний урьдчилсан цахим бүртгэлийн тогтолцоог нэвтрүүлж, гадаадын иргэнийг хилээр нэвтрэхээс өмнө мэдээллийг авах, нэгдсэн бүртгэлийн системийг бүрдүүлэх, гадаадын иргэний бүртгэлд бүрэн хамруулснаар тэдгээрт хяналтын үр нөлөө нэмэгдэж, хил дээрх ачаалал буурах, шилжилт хөдөлгөөнийг илүү нэгдмэл байдлаар зохион байгуулах боломж бүрдэнэ;

3.Мөн иргэн, хуулийн этгээдэд учирч байсан хаягийн бүртгэлтэй холбоотой давхардсан хүндрэл бэрхшээлийг арилгаж, төрийн байгууллагуудын цахим мэдээллийн уялдааг сайжруулж, төрийн үйлчилгээний хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлэх эерэг үр дүн бий болно;

4.Гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийн төрөл, ангиллыг визийн ангилалтай уялдуулан тодорхой болгож, гадаадын иргэний оршин суух төрөл шат дамжлага, ангиллын давхардал арилна. Түүнчлэн оршин суух зөвшөөрөл олгох,

сунгах, цуцлах, хянан шийдвэрлэх ажиллагааг зөвхөн хуульд тусгаж өгснөөр хүний эрх, эрх чөлөөг журмаар хязгаарлаж байсан асуудал шийдвэрлэгдэж, эерэг нөлөө үзүүлнэ;

5. Гадаадын иргэдийн хяналт, шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд урьдчилсан цахим бүртгэл, хил нэвтрэлтийн мэдээллийн сан болон гадаадын иргэний бүртгэлийн нэгдсэн мэдээллийн санг уялдуулан ашиглах эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгосноор гадаадын иргэдийн хөдөлгөөнийг технологид суурилсан арга замаар хяналт тавих шинэ зохицуулалт бүрдэнэ;

6. Гадаадын иргэнтэй холбоотой чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн бусад байгууллагын албан хаагч гадаадын иргэний тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын тогтолцоо боловсронгуй болохоос гадна тухайлан виз, бүртгэлийн зөрчилтэй болон Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн, орохыг үл зөвшөөрсөн гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлсэн эрх бүхий албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэснээр төрийн байгуулага, албан тушаалтны үүрэг, хариуцлага сайжирна;

7. Мөн Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэхтэй холбоотой зохицуулалтыг бусад хууль тогтоомжтой уялдуулах, гадаадын иргэнийг саатуулах үндэслэл, хугацаа, эрх бүхий байгууллагын бүрэн эрх тодорхой болж, зөрчлийг шуурхай шийдвэрлэх боломж бүрдэнэ;

8. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчдын эрх зүйн байдал, хуулиар олгосон нийгмийн баталгаа сайжирч, төрийн албан хаагчийн тогтвортой ажиллах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нөхцөл бүрдэнэ;

9. Сүүлийн жилүүдэд гадаадын иргэний Монгол Улсад зорчих, оршин суух, хөдөлмөр эрхлэхтэй холбоотой хяналт шалгалтын явцад эрх бүхий албан тушаалтны хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, шалгалтаас зайлсхийх, албан үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс нөлөөлөх, хяналт шалгалтыг саадгүй хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор виз олгох, сунгахаас татгалзах, цуцлах, хүчингүй болгох болон хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх зохицуулалт бий болно.

Дөрөв. Хуулийн төсөл Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон Олон Улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөлтэй холбогдуулан Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг дагалдуулан боловсруулна.

-----oOo-----